

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Агваандаржаа	Дугаар	L336
Оршин суугаа аймаг	Дундговь аймаг	Оршин суугаа сум	Цагаандэлгэр сум
Төрсөн газар	Цагаандэлгэр сум	Төрсөн он	1916
Ажил мэргэжил	Лам		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Баруун Чойрын хийд	Сүм хийдийн дугаар	ДУЦД 071
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 8-р сарын 5	Ярилцлага авсан хүн	Энхбаяр

Дундговь аймгийн Цагаандэлгэр сумын Баруун Чойрын хийд

Дундговь аймаг, Цагаандэлгэр сум, Баруун Чойрын хийдийн тухай

Жужа: 2007 оны 8 сарын 5-ны өдөр Цагаандэлгэр сумын төв дээр Агваандаржаа гуайгаас ярилцага авч байна. За Агваандаржаа гуай бол Баруун Чойрын хийдийн шавилж сууж байсан хүн.

Энхбаяр: Өвөө, өөрийн чинь тухай эхлээд асууя. Анх та хэдэн настай лам болсон бэ?

Агваандаржаа: Энэ юу юм бэ?

Энхбаяр: Энэ дуу хурааж байна.

Агваандаржаа: За нэг арав орчим настай байсан юм болов уу, шавилж эхэлсэн байх.

Энхбаяр: Та дэлгэрийн Баруун Чойрын хийдэд сууж байсан, энэ хийдийнхээ тухай ярьж өгнө үү?

Одоо санаж бодож явдаг юм юу байна, хэдэн дацантай байсан юм?

Агваандаржаа: Чойр, ёга, дүйнхор, гүнриг, хайлан, мамба гээд ер нь нэлээн хэдэн дацантай байсан шүү.

Энхбаяр: Хэд орчим ламтай байсан юм бол?

Агваандаржаа: Мянга орчим ламтай байсан байх. Тэгж ярьдаг.

Энхбаяр: Та аль дуганд хурж байв?

Агваандаржаа: Би Чойрын дуганд сууж байсан.

Энхбаяр: Та хэдэн жил сууж байсан бэ?

Агваандаржаа: Би 12 жил суусан.

Энхбаяр: Та аль зиндаад байсан? Одоо Чойрын аль зиндаад гэсэн үг?

Агваандаржаа: Аан, за байз...за одоо хуврагийн зиндаа юм уу

Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно.

1